



ТӨРИЙН ӨМЧИЙН 6 ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛУУДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны 02 дугаар сарын 28 ны өдөр Дугаар А/36, А/37, А/40, Улаанбаатар хот
... А/46 А/63

Г Номын сангаар үйлчилгээ үзүүлэх журам батлах тухай Г

Номын сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх хэсэг, 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан “Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн 2 дугаар зүйлийн 2.3.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн өмчийн их сургуулиудын номын сангаар үйлчилгээ үзүүлэх журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг “Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичиг”-т хамаарах сургуулиуд санамж бичгийн хүчинтэй байх хугацаанд мөрдөж ажилласугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Эрдэм шинжилгээ, гадаад харилцаа хариуцсан дэд захирал /Б.Дамдиндорж/, Монгол Улсын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал /Н.Батхүү/, Хөдөө аж ахуйн их сургуулийн Эрдэм шинжилгээ, инновац эрхэлсэн дэд захирал /Г.Гантулга/, Монгол Улсын боловсролын их сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал /Д.Наранцэцэг/, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал /Д.Мягмарсүрэн/, Соёл, урлагийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, инновац эрхэлсэн дэд захирал /Ж.Эрхэмтөгс/ нарт үүрэг болгосугай.

АНАГААХЫН ШИНЖЛЭХ
УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Н.ХҮРЭЛБААТАР



УХД0074 5845455

МОНГОЛ УЛСЫН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Б.ОЧИРХУЯГ




1117144746
УХД0072 9104399

ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Т.ХЭРҮҮГА




9026670105 8093355

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ ДЭД
ПРОФЕССОР О.АЛТАНГОО



9087702 9021051159

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Т.НАМНАН




MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY
СТАЛБЫН № 9087087

СОЁЛ, УРЛАГИЙН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Э.СОНИНТОГОС



УХД0053



НОМЫН САНГААР ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Номын сангууд нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Номын сангийн тухай хууль, Соёлын тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Засгийн Газрын шийдвэр, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенц, Номын сангийн орчны үйл ажиллагаанд тавигдах стандарт, тухайн сургуулийн дүрэм, номын сангийн журам болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
- 1.2 Номын сан нь багш, ажилтан, докторант, судлаачид, магистрант, оюутан, сурагчдад /цаашид уншигч гэнэ/ номын сангийн үйлчилгээ үзүүлж, номзүйн мэдээллээр ханган, мэдлэг, боловсролоо дээшлүүлэхэд нь туслах үүрэг хүлээнэ.
- 1.3 Номын сангууд нь уншигчдад хүртээмжтэй, шуурхай, тэгш үйлчлэх, үйлчилгээний ёс зүйн хэм хэмжээг баримтлах, нээлттэй, ил тод байдлыг хангах зэрэг үнэт зүйлсийг баримтална.

Хоёр. НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- 2.1 Төрийн өмчийн 6 их сургуулийн /МУИС, МУБИС, АШУУИС, ШУТИС, ХААИС, СУИС/ номын сангууд нь /хамтын ажиллагаатай дээрх төрийн өмчийн 6 их сургуулийн/ уншигчдад дараах үйлчилгээг үзүүлнэ.
 - 2.1.1 Уншлагын танхимаар үйлчлэх
 - 2.1.2 Ном, хэвлэлийн бүтээгдэхүүнээр үйлчлэх
 - 2.1.3 Лавлагаа, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх
 - 2.1.4 Хэвлэх, хувилах, сканердах үйлчилгээ үзүүлэх
 - 2.1.5 Олон улсын шинжлэх ухааны цахим мэдээллийн санг ашиглах боломжийг бүрдүүлэх
 - 2.1.6 Эрдэм шинжилгээний шинэ ном, бүтээлийн мэдээ, мэдээллийг хүргэх
- 2.2 Номын сангууд нь бусад сургуулийн уншигчдад үйлчлэхдээ ажлын газрын үнэмлэх, оюутны үнэмлэхийг үндэслэн үйлчилгээ үзүүлнэ.
- 2.3 Номын сангийн программд уншигчийн эрх нээхдээ уншигчийн албан ёсны цахим шуудангийн хаягийг үндэслэн 1 жилийн хугацаатай нээнэ.

- 2.4 Уншигч тухайн номын сангийн дотоод журмыг зөрчсөн тохиолдолд үйлчилгээний эрхийг хаах, уншигчийн мэдээллийг харьяа сургууль, номын санд мэдэгдэнэ.

Гурав. БУСАД

- 3.1. Номын сангаар үйлчлүүлсэн уншигчдын тайлан мэдээг нэгтгэн холбогдох сургууль, номын сангуудад илгээнэ.
- 3.2. Энэхүү журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал, гомдлыг тухайн их сургуулийн номын сан хүлээн авч холбогдох журмын хүрээнд шийдвэрлэнэ.
- 3.3. Энэхүү журам болон хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг төрийн өмчийн 6 их сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.

Төрийн өмчийн 6 их сургуулийн номын сангуудын цагийн хуваарь

№	Сургуулиуд	Ажиллах өдөр	Холбоо барих
1	АШУУИС	Пүрэв, Баасан	library.support@mnums.edu.mn
2	МУИС	Лхагва, Пүрэв	75754400-1425
3	ХААИС	Лхагва, Пүрэв	75107777-171
4	МУБИС	Мягмар, Баасан	library@msue.edu.mn
5	ШУТИС	Пүрэв, Баасан	11324590-1026
6	СУИС	Пүрэв, Баасан	70137056